

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН 2019-2023 ОНЫ ТАНИЛЦУУЛГА

Манай улсад 2023 оны эцэст нийт 983.5 мянган өрх бүртгэгдсэний 17.7 мянган өрх буюу 1.8 хувь нь тариалан эрхэлсэн өрх байна. Газар тариалан эрхэлсэн өрхийн тоо өмнөх оноос 55 өрх буюу 0.3 хувиар буурсан байна. Газар тариалан эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2023 онд 1553 болж, өмнөх оноос 37 буюу 2.3 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГА

	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	тоо				Дүн	Хувь
Өрх	18 348	14 678	17 738	17 683	-55	-0.3
ААНБ	1 395	1 401	1 590	1 553	-37	-2.3

Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайлангийн дүнгээр хөдөө ахуйн эдэлбэр газар 109.0 сая га байгаа бөгөөд үүнээс тариалангийн газар 1149.0 мянган га буюу 1.1 хувийг эзэлж байна. 2023 онд нийт 645.8 мянган га талбайд тариалалт хийсэн нь тариалангийн газрын 56.2 хувийг хамарч байна.

ХҮСНЭГТ 2. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, тариалангийн газрын төрлөөр

Төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган га				Дүн	Хувь
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар¹	114 982.8	114 736.7	113 567.1	109 036.2	-4 530.9	- 4.0
Тариалангийн газар ¹	1 028.2	1 117.2	1 139.9	1 149.0	9.1	0.8
Атаршсан газар ¹	305.0	216.6	215.5	214.7	- 0.8	- 0.4
Уринш хийсэн талбай ²	335.8	350.6	313.7	278.6	- 35.1	- 11.2
Тариалсан талбай ³	527.7	526.0	621.7	645.8	24.1	3.9
Тариалсан талбай тариалангийн газарт эзлэх хувь	51.3	47.1	54.5	56.2	1.7	3.1

¹Эх үүсвэр - Газрын нэгдмэл сангийн тайлан

²Эх үүсвэр -ХХААХҮЯ-ны Уринш элдэншүүлгийн захиргааны мэдээ /З-ХАА-1/

³Эх үүсвэр - Өрх, ААНБ-ын тариалсан талбайн жилийн мэдээ /А-ХАА-7/

Улсын хэмжээгээр 2023 онд нийт 645.8 мянган га-д тариалалт хийсэн нь 2015 оноос 118.1 мянган га буюу 22.4 хувиар, 2019 оноос 119.7 мянган га буюу 22.8 хувиар, өмнөх оноос 24.1 мянган га буюу 3.9 хувиар өсжээ. Ургамлын төрлөөр авч үзвэл, 2023 онд үр тариа 363.1 мянган га-д, төмс 19.4 мянган га-д, хүнсний ногоо 15.8 мянган га-д, таримал тэжээл 106.9 мянган га-д, техникийн ургамал 136.9 мянган га-д, эмийн болон бусад ургамал 0.1 мянган га д, жимс, жимсгэнэ 3.5 мянган га-д тус тус тариалжээ.

ХҮСНЭГТ 3. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

Ургамлын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган га				Дүн	Хувь
Нийт тариалсан талбай	527.7	526.0	621.7	645.8	24.1	3.9
Үр тариа	390.7	369.4	385.1	363.1	-22.0	-5.7
Буудай	361.2	343.5	358.0	335.8	-22.1	-6.2
Төмс	12.8	14.9	21.0	19.4	-1.6	-7.6
Хүнсний ногоо	7.7	8.4	14.2	15.8	1.6	11.1
Таримал тэжээл	23.8	43.8	73.5	106.9	33.4	45.5
Техникийн ургамал	84.5	86.2	124.1	136.9	12.8	10.3
Эмийн болон бусад ургамал	5.5	0.3	0.7	0.1	-0.6	-86.4
Жимс, жимсгэнэ	2.7	3.0	3.0	3.5	0.5	16.8

Нийт тариалсан талбайг аж ахуйн төрлөөр нь авч үзвэл, ААНБ-д үр тарианы талбайн 92.2 хувь, таримал тэжээлийн талбайн 58.5 хувь нь ногдож байгаа бол иргэд, өрхийн аж ахуйд төмсний талбайн 74.5 хувь, хүнсний ногооны 77.2 хувь нь тус тус ногдож байна. Сүүлийн жилүүдэд таримал тэжээлийн өрхийн тариалалт нэмэгдсээр байна.

ХҮСНЭГТ 4. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, аж ахуйн төрлөөр, хувиар

Ургамлын төрөл	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	ААНБ				Өрх			
Нийт тариалсан талбай	86.3	86.2	81.4	81.3	13.7	13.8	18.6	18.7
Үр тариа	91.2	91.4	90.2	92.2	8.8	8.6	9.8	7.8
Төмс	25.7	22.1	17.7	25.5	74.3	77.9	82.3	74.5
Хүнсний ногоо	20.4	20.9	19.3	22.8	79.6	79.1	80.7	77.2
Таримал тэжээл	70.3	74.0	59.0	58.5	29.7	26.0	41.0	41.5
Техникийн ургамал	83.2	89.3	85.6	85.4	16.8	10.7	14.4	14.6

Манай улс 2023 онд 470.3 мянган тонн үр тариа, 179.4 мянган тонн төмс, 208.4 мянган тонн хүнсний ногоо, 258.2 мянган тонн таримал тэжээл, 55.4 мянган тонн техникийн ургамал, 2.3 мянган тонн жимс, жимсгэнэ хураасан нь 2022 оноос төмс 34.6 мянган тонноор буюу 16.2 хувиар, жимс, жимсгэнэ 0.3 мянган тонноор буюу 10.7 хувиар буурсан бол таримал тэжээл 87.0 мянган тонноор буюу 50.8 хувиар, хүнсний ногоо 59.5 мянган тонноор буюу 40.0 хувиар, үр тариа 41.7 мянган тонноор буюу 9.7 хувиар, техникийн ургамал 6.2 мянган тонноор буюу 12.5 хувиар тус тус өссөн байна. Хураан авсан 2023 оны ургацыг “Атрын III аян”-ы өмнөх таван жилийн дундажтай харьцуулж үзвэл, хураасан үр тариа 343.8 мянган тонн буюу 3.7 дахин, төмс 86.4 мянган тонноор буюу 92.9 хувь, хүнсний ногоо 144.4 мянган тонноор буюу 3.3 дахин тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5. ХУРААСАН УРГАЦ,

Ургамлын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган тонн				Дүн	Хувь
Үр тариа	216.3	433.3	428.6	470.3	41.7	9.7
Буудай	203.9	411.4	401.9	443.4	41.5	10.3
Төмс	163.8	192.2	214.0	179.4	-34.6	-16.2
Хүнсний ногоо	72.3	99.5	148.9	208.4	59.5	40.0
Таримал тэжээл	49.2	121.1	171.2	258.2	87.0	50.8
Техникийн ургамал	23.1	34.0	49.2	55.4	6.2	12.5
Жимс, жимсгэнэ	1.4	1.8	2.6	2.3	-0.3	-10.7
Бэлтгэсэн хадлан	1 028.7	1 369.2	1 562.5	1 564.7	2.2	0.1

Хураасан үр тарианы хэмжээ “Атрын II аян” хэрэгжүүлсний дараагийн жил буюу 1979 оноос 109.8 мянган тонн буюу 30.5 хувиар, төмс 105.7 мянган тонноор буюу 2.4 дахин, хүнсний ногоо 181.6 мянган тонноор буюу 7.8 дахин нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6. ХУРААСАН УРГАЦ, сонгосон онуудаар

	1962	1979	2003-2007 оны дундаж	2015	2019	2022	2023
	мянган тонн						
Үр тариа	326.5	360.5	126.5	216.3	433.3	428.6	470.3
Төмс	23.9	73.7	93.0	163.8	192.2	214.0	179.4
Хүнсний ногоо	13.3	26.8	64.0	72.3	99.5	148.9	208.4

Тайлбар: Атрын I, II аян хэрэгжүүлсний дараах жил буюу 1962, 1979, Атрын III аяны өмнөх 2003-2007 онуудтай харьцуулав.


ГА-ГИЙН УРГАЦ:

2023 онд 1 га-гаас дунджаар 13.0 центнер үр тариа, 92.3 центнер төмс, 132.0 центнер хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1 га-гаас авсан төмс 9.5 центнерээр буурсан бол хүнсний ногоо 27.2 центнер, үр тариа 1.8 центнерээр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ГА-ГИЙН УРГАЦ

	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	центнер				Дүн	Хувь
Үр тариа	5.5	11.7	11.1	13.0	1.8	16.4
Төмс	127.7	128.7	101.8	92.3	-9.5	-9.3
Хүнсний ногоо	94.5	118.0	104.8	132.0	27.2	25.9

ЗУРАГ 1. ҮР ТАРИАНЫ ГА-ГИЙН УРГАЦ, центнерээр




Үр тарианы хувьд, 1985 онд түүхэндээ хамгийн их буюу 886.2 мянган тонн үр тариа хурааж байх үед 1 га-гаас 13.9 центнер үр тариа авч байсан дээд үзүүлэлт нь 2014 онд 16.5 центнер болж шинэчлэгдсэн. Харин 2023 онд 1 га гаас авсан ургацын хэмжээ 13.0 центнер болж буурсан байна. 2023 онд 1 га-гаас хураан авсан үр тариаг өмнөх онтой харьцуулбал, Завхан, Сүхбаатар, Дундговь, Увс, Дорнод, Хэнтий аймагт 0.5-4.6 центнерээр буурч, харин бусад аймагт 1.2-35.0 центнерээр өссөн байна.

ЗУРАГ 2. ҮР ТАРИАНЫ ГА-ГИЙН УРГАЦ, 2023 он, центнерээр



1 га-гаас хураан авсан хүнсний ногоо Төв, Өвөрхангай, Увс, Өмнөговь, Баян Өлгий, Сүхбаатар аймгуудад 2.3-18.5 центнерээр буурч, бусад аймагт 4.2-71.1 центнерээр өссөн байна.

ЗУРАГ 3. ХҮНСНИЙ НОГООНЫ ГА-ГИЙН УРГАЦ, 2023 он, центнерээр



1 га-гаас хураан авсан төмс Өвөрхангай, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Булган, Орхон, Сүхбаатар, Төв, Баян-Өлгий аймгуудад 0.9-47.5 центнерээр буурч, бусад аймагт 0.1-35.7 центнерээр өссөн байна.

ЗУРАГ 4. ТӨМСНИЙ ГА-ГИЙН УРГАЦ, 2023 он, центнерээр



Гаалийн Ерөнхий Газар, ҮСХ-ны албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тооцоход, 2023 онд улсын хэмжээгээр 491.1 мянган тонн улаан буудай, 181.5 мянган тонн төмс, 300.7 мянган тонн хүнсний ногоог дотоодын зах зээлд нийлүүлснээс дотоодын үйлдвэрлэлээр төмсний хэрэгцээний 98.8 хувь, улаан буудайн 90.3 хувь, хүнсний ногооны 69.3 хувийг хангаж, үлдсэн хувийг импортоор хангасан байна.

ХҮСНЭГТ 8. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ

	Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт = дотоодын үйлдвэрлэл+импорт-экспорт				Дотоодын үйлдвэрлэл			
	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	мянган тонн							
Улаан буудай	225.0	425.8	402.2	491.1	203.9	411.4	401.9	443.4
Төмс	180.8	192.6	214.4	181.5	163.8	192.2	214.0	179.4
Хүнсний ногоо	126.5	183.0	218.6	300.7	72.3	99.5	148.9	208.4
үргэлжлэл								
	Импорт ¹				Экспорт ¹			
	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	мянган тонн							
Улаан буудай	21.1	14.4	0.3	47.7	-	-	-	-
Төмс	17.1	0.4	0.4	2.1	-	-	-	-
Хүнсний ногоо	54.9	83.4	69.7	92.3	0.7	0.0	0.0	0.0

¹Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газрын Мэдээлэл

2022 онд 1 га талбайгаас хураан авсан үр тарианы хэмжээг дэлхийн дундажтай харьцуулан авч үзэхэд 23.2 центнерээр бага байна.

ЗУРАГ 5. ҮР ТАРИАНЫ ГА-ГИЙН УРГАЦ, центнерээр



2022 онд 1 га-гаас хураасан төмсний ургацыг дэлхийн дундажтай харьцуулан авч үзэхэд 108.7 центнерээр бага байна.

ЗУРАГ 6. ТӨМСНИЙ ГА-ГИЙН УРГАЦ, центнерээр

